

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025.06.10

Улаанбаатар хот

№	Гэрээгээр хүлээсэн чиг үүрэг	Хэрэгжилт	Үнэлгээ /хувь/
1.	2.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хот дахин хөгжүүлэх төсөл, орлогод нийцсэн орон сууцны төслүүдийн тайлан, хэрэгжилтийг тухай бүрд холбогдох байгууллага, дээд газарт хүргүүлэн ажилласан. Мөн Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал” болон 2023 оны “Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай” 264 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд үнэлгээ хийж, илгээсэн. Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны А/55, А/124 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаал, захирамжийн хүрээнд Эрчим хүчний яам, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Газар зохион байгуулалтын алба зэрэг ажлын хэсгийн гишүүн байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын орон сууцжуулах төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цахилгаан, дулааны хэрэглээний өсөлтийг тодорхойлж, дэд бүтцийн ажлуудын байршлын асуудлыг нарийвчлан тогтоох, ажлын тоо, хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоолж, ажлын хэсгийн дарга, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх орон сууцны төслүүдийн газар чөлөөлөлт, дэд бүтцийн зардлын тооцооллыг боловсруулж, хэрэгжүүлэх үе шатаар	100%

		буюу 2025-2028, 2029-2032 он хүртэл санхүүжилтийн эх үүсвэрийн задаргааг гаргаж, Нийслэлийн Засаг Даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч Т.Даваадалайн хамт Сангийн яаманд танилцуулсан. Тус газрын дүрмийн 4 дэх хэсэг газрын үндсэн чиг үүргийн 4.3.1-д зааснаар ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, төсөл хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэх тухай дүгнэлтийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаж, Нийслэлийн Засаг Даргын 2024 оны А/691 дүгээр захирамжаар байгуулагдсан Хяналтын хорооны 4 удаагийн хурлаар 11 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдол саналыг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, 7 (Баганат өргөө ХХК, Грандлайн ХХК, Андын зам констракшн ХХК, Бүрд констракшны ГХДТ ХХК, Грийн ресурс констракшн ХХК, Очирням проперти девелопмент ХХК, Бармон ХХК) төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч 4 (Голден мартин ХХК, Монголиан инвестмент корпорейшн ХХК, Газрын эзэн Баянзүрх ЗБН, Ланкастер ХХК) төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах тухай Нийслэлийн Засаг Даргын 2025 оны А/557, А/558, А/639, А/640 дугаар захирамж гарсан.	
2.	2.2. Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах	Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж, хагас жилээр тайлагнан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газарт хүргүүлсэн.	100%
3.	2.3. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах	Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт ТЗ-19, ТҮ-2, ТҮМ-3 нийт 24 албан хаагч нар өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэхдээ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албанд мерит тогтолцоог хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд: 2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны зөвлөлд 5 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалга хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн 2024 оны 133 дугаар тогтоолыг үндэслэн 1 албан хаагчийг томилсон. Засгийн газрын 2023 оны 301, 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 43 дугаар	100%

		тушаалын дагуу 24 албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг үнэлсэн.	
4.	2.4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах ажлын хүрээнд: 1. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор үнэн зөв гаргаж, Нийслэлийн Төрийн санд цаг хугацаанд нь хүргүүлж, төсвийн шууд зардлын өр авлагагүй, зардлын хэтрэлгүй ажилласан. 2. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 05-ны өдөр дотор гаргаж, цахим системд оруулан баталгаажуулалт хийж ажилласан. 3. Хувь хүний орлогын албан татварын 1 дүгээр улирлын тайланг хуулийн хугацаанд нь гарган татварын нэгдсэн системд шивж оруулсан. 4. Тайлант хугацаанд батлагдсан төсвийн 52,7 % буюу 390,8 сая төгрөгийг зарцуулж, 47,3 % буюу 350,9 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.	100%
5.	2.5. Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах	Тайлант хугацаанд нийт 12 маргаанд Нийслэлийн Засаг Даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнээс Захиргааны хэргийн шүүхэд 6, иргэний хэргийн шүүхэд 6 маргаан байна. Эдгээр маргаанаас анхан шатны шүүхэд 10, давж заалдах шатанд 2 маргаан байна. Тайлант хугацаанд шинээр 3 хэрэг үүссэн хуулийн хүчин төгөлдөр болж дууссан маргаан байхгүй.	100%
6.	2.6. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;	Баянхошуу, Шархад дэд төвд баригдаж буй ногоон, эрчим хүчний хэмнэлттэй 800 өрхийн орон сууцны барилгын угсралтын ажилтай Нийслэлийн Ерөнхий архитектор болон холбогдох албаны мэргэжилтнүүдтэй хамтран танилцаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргэн ажилласан.	100%
7.	2.7. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих журам”, 2018 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-д хуулийн хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудын хүрээнд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг Даргын 2024 оны “Захиалагчийн хяналт тавих тухай” А/164	100%

		дүгээр захирамжийн дагуу гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний гэрээт 11 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж, захиалагчийн хяналтыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т үүрэг болгосон. Мөн тус захирамжаар батлагдсан Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн. Үндэсний баялагийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны үйл ажиллагааг мэдээллээр хангах ажлын хүрээнд 2032 он хүртэл Улаанбаатар хотод хэрэгжих орон сууцны төслүүдийн төлөвлөгөөг танилцуулсан бөгөөд Ипотекийн зээлийн журамд өөрчлөлт оруулах үйл ажиллагааны хүрээнд санал боловсруулж ажилласан. Тодруулбал, өмнөх жилүүдэд олгогдсон ипотекийн зээл нь агаар, орчны бохирдолтой тэмцэхэд ач холбогдол багатай байсан тул бүсчилж олгох шаардлагатайгаас гадна газар чөлөөлсөн иргэдийн зорилтот бүлэгт хамруулж, эхний ээлжинд ипотекийн зээл олгох саналыг хүргүүлэн ажиллалаа.	
8.	2.8. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах	Хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн нийт 12 чиг үүрэгтэй. Үүнд: 1. Хот, суурийн газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд-3 2. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр -2 3. Дахин хөгжүүлэх төслүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр-3 4. Нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр-2 5. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний чиглэлээр -2 гээд тус тус 12 үндсэн чиг үүрэг байна. Дээрх чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтыг тус газрын 5 хэлтэс хэрэгжүүлэн мөрдөж, тайлагнаж ажилласан.	90%
9.	2.9. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх	Байгууллагын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд нийт 25 албан хаагчаас сургалтын хэрэгцээг тодорхойлох, цаашид суралцах шаардлагатай сургалтын саналыг авсны дагуу Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтэстэй хамтран нийт 25 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 63 албан хаагчийг хамруулсан.	100%

		Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний дагуу 25 албан хаагчид Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын дагуу цалин хөлсийг шинэчилсэн хэмжээгээр олгож байна. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал, түүнээс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, албан хаагчдын ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажлын цагийн хуваарьт уян хатан байдлыг бүрдүүлэн ажилласан. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний дагуу: ➢ Буцалтгүй тусламж-5 ➢ Зэрэг дэвийн нэмэгдэл-5 албан хаагчид олгосон байна.	
10.	2.10. Алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах	Газрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай гарын авлагыг бэлтгэн танилцуулсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчилгүй, ажлын гүйцэтгэлийн алдагдалгүй ажилласан байна.	90%
11.	2.11. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх	Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шуурхай чирэгдэлгүй байх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Байгууллагаар үйлчлүүлэхээр ирсэн болон утсаар мэдээ мэдээлэл авсан иргэдээс үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд нийт 12700 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.	100%
12.	2.12. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх	Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/03 дугаар албан шаардлагын зөрчил дутагдлыг арилгах үүрэг бүхий Ажлын хэсгийг газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулсан. Нийт 9 шаардлага ирүүлсэн бөгөөд иргэний гомдлыг Хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025/01 дүгээр шийдвэр гаргуулсан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах зорилгоор дотоод хяналт шалгалтыг сар тутам хийх төлөвлөгөөг баталж, албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “өргөдөл, гомдлыг бүрэн судалж, хууль зүйн үндэслэлтэй, хариу өгч, холбогдох мэдээ, мэдээллээр хангаж, зөрчилгүй ажиллана” гэсэн арга хэмжээг тусгасан. Газрын даргын 2025 оны Б/19, Б/20 дугаар тушаалаар хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 4 зөрчлийг арилгасан, даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар ажлын цагт уян хатан зохицуулалт хийх зэрэг холбогдох бусад арга хэмжээг хэрэгжүүлсэн.	100%
13.	2.13. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-	2.14. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот	100%

	ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах	захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтэд анхаарал хандуулан ажиллаж байна.	
14.	2.14. Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох	Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 58 дугаар тушаалаар байгуулагдсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийг дагалдуулан баталсан журам, гэрээний загварын нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих журам”, 2018 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-д хуулийн хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудын хүрээнд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Газар зохион байгуулалтын алба, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар болон Бодлогын судалгаа, шинжилгээний төвтэй хамтран ArcGis программд суурилсан дотоодын мэдээллийн санг үүсгэж, баяжуулалтыг тогтмол хийж ажиллаж байна.	100%
15.	2.15. Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах	Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар: 1. Барилгын үйл ажиллагаанд тавигдах стандартын мэдээллийг “Хотын стандарт”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэвийн үргэлжилж буй 34 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл өгч, гарын авлага хүргүүлсэн. 2. Алсын хараа – 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн 2025 оны тайлангийн “Улаанбаатар ба дагуул хот” 9 дүгээр бүлгийн төлөвлөлт төвтэй шийдэл болон орчин төвтэй шийдэл хэсэгт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй барилгын талаарх мэдээллийг стандартын дагуу боловсруулан оруулж, иргэд, олон нийтэд сурталчлах боломжийг бүрдүүлсэн. 3. Ногоон, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихтай холбоотой 7	100%

		мэдээ болон гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоосон талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлэл өгч ажиллсан бөгөөд газрын фэйсбүүк хуудас https://www.facebook.com/profile.php?id=61566563750022 болон албан ёсны нүүр хуудсаар https://hpa.ub.gov.mn/ дамжуулан тухай бүрд сурталчилж таниулсан.	
16.	2.16. Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх	Газрын фэйсбүүк хуудас https://www.facebook.com/profile.php?id=61566563750022 болон албан ёсны нүүр хуудсаар https://hpa.ub.gov.mn/ дамжуулан үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, холбогдох шийдвэр, үйл явцыг ил тод сурталчилж, 12,700 иргэнийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.	100%
17.	2.17. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах ажлын хүрээнд тус газарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүсэлт 223, гомдол 104, талархал 1, санал 3 гээд нийт 335 өргөдөл ирсэн. Шийдвэрлэсэн 313 буюу шийдвэрлэлтийн хувь 93,4%, дундаж хугацаа 5,19 хоног байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр нийт албан хаагчдыг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс “Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд анхаарах зүйлс” сургалтад хамруулсан. Хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй байна.	100%
18.	2.18. Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг тогтоосон хугацаанд нь биелүүлж, явц үр дүнг тухай бүр тайлагнаж, Нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариунд анхаарал хандуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	100%
19.	2.19. Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлэн ажилласан.	100%
20.	2.20. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн	Байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор газрын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээллэн ажилласан.	80%

	дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх		
21.	2.21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах	Тайлант онд Шилэн дансны цахим системд тавигдах ёстой нийт 171 мэдээллээс 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 68 мэдээлэл оруулах ёстойгоос 67 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан.	90%
22.	2.22. Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах	Европын Сэргээн босголт, хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын байгуулсан “Улаанбаатар хотын ногоон орон сууц” төслийн зээлийн хэлэлцээрийн Ажлын хэсэгт орж, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Төслийн зээлийн хэлэлцээрийг Засгийн Газрын хурлаар 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хэлэлцсэн. Төслийн Удирдах хорооны 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр хурлаар тухайн оны үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөг баталсан. Төслийн загвар зургийг “Green Engineering Kz LLP”-тай хамтран ажиллаж баталгаажуулсан. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн захирамжаар Төслийн нэгжийн гарын авлага, төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлуулсан. Тус төслийн нэгж нь Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 142 дугаар тушаалаар байгуулагдсан. Харин Үнэлгээний хороог Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/386 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд урьдчилсан сонгон шалгаруулалтын тендерийг 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зарлан ажилласан. Мөн "Баянголын амын түрээсийн орон сууц төсөл"-ийн хүрээнд зураг төсөл боловсруулах, хяналт тавих болон чадавх нэмэгдүүлэх зөвлөх үйлчилгээ авахаар Бүгд Найрамдах Солонгос улсын “Аум энд Лий” консорциумтай 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гэрээ байгуулж байсан ба тус төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Ил Сүнг” ХХК шалгарч, 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гэрээг байгуулсан. Төслийн Удирдах хороог Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/99 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулсан. Удирдах хороонд тус газар гишүүн болон Нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж байгаа.	90%

23.	2.23. Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх	Баянхошуу, Шархад дэд төвд баригдаж буй ногоон, эрчим хүчний хэмнэлттэй 800 өрхийн орон сууцны барилгын угсралтын ажилтай Нийслэлийн Ерөнхий архитектор болон холбогдох албаны мэргэжилтнүүдтэй хамтран танилцаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргэн ажилласан.	100%
24.	2.24. Нийслэлийн Засаг даргын "2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх	"Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд Хан-Уул, Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороонд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлж буй 34 төсөл хэрэгжүүлэгч компаниуд "Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд орон сууцны хороолол дундах гадна 13 км авто зам, 300 орчим гадна авто зогсоол, гадна гэрэлтүүлэг, 400 ширхэг мод бут сөөг тарьсан байна.	90%
Нийт үнэлгээ			94,5%

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БОЛОРТУЯА

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯЛАГ

БОЛОВСРУУЛСАН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ,
ТАЙЛАН МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.ХОРОЛСҮРЭН